**ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТЭР** **НИЙГЭМ СУДЛАЛ 10 АНГИ**




*Энэхүү дасгал, даалгаврыг гүйцэтгэхдээ сурах бичгийн агуулгыг уншиж судлах, теле , цахим хичээлээ давтан үзэх, судалж буй агуулгад холбогдох нэмэлт мэдээлэл, эх сурвалж судлах зэргээр ажиллаарай.*

## Судлах бүлэг




- Энэхүү 4 бүлэг сэдэв, дэд агуулгын хүрээнд тулгуур ойлголт, нэр томьёо тайлбарлах, тохиолдол, эх сурвалж шинжлэх, мэдээлэлтэй ажиллах, ойлголтыг жишээгээр тайлбарлах, дүн шинжилгээ хийх, үндэслэл, нотолгоо гаргах, шүүн тунгаах, эргэцүүлэмж, эссээ бичих зэргээр мэдлэг, ойлголтоо бататгахын зэрэгцээ чадвар, хандлагаа хөгжүүлэх болно.
- Сурагч та бие даан суралцах дэвтэртэй ажиллахдаа илүү хариуцлагатайгаар цагийг үр дүнтэй ашиглан найз нөхөд, багштайгаа хамтран ажиллах зэргээр бие даан бүтээлчээр суралцаарай.
- Дасгал, даалгавар нь 3 түвшинтэй бөгөөд дараах алмын дагуу суралцахуйн замын зураглалаа хөтлөн өөрийн суралцах үйлээ удирдан ажиллаарай.

| I | II | III |
|---|---|---|

| Түвшин | Блумын таксономийн танин мэдэхүйн үйл |
|---|---|
| I | Сэргээн санах, ойлгох |
| II | Хэрэглэх, задлан шинжлэх |
| III | Үнэлэх, бүтээх |

| | |
|---|---|
| I алхам | Өөрийгөө үнэлэн мэдлэг, чадварын түвшнээ тогтоохын зэрэгцээ болон багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай. |
| II алхам | Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохиорох түвшний өнгөөр будаарай. |
| III алхам | Тухайн бүлгийн дасгал, даалгаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дусссан хугацааг заавал тэмдэглээрэй. |
| IV алхам | Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй. |
| V алхам | Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу ажилласан дасгал, даалгавраа сайжруулаарай. |



10-3. Эрх зүй

I II III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусан: Он, сар, өдөр*

1. Ойлголтуудыг тайлбартай нь зөв тохируулан хүснэгтийн хоосон зайд тохирох *үсгийг* бичээрэй.

| **Хүний эрх** | **Эрх зүйд захирагдах ёс** | **Үндсэн хуулийн суурь зарчим** | **Хүний эрхэм чанар** |
|---|---|---|---|
| Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. | Хүн бүр хүн болох хувьдаа адил үнэ цэнтэй бөгөөд тодорхой үндсэн эрх, эрх чөлөөг эдэлдэг. | Танд байх ёстой бүх эрхүүд юм. | Улс орны төр засгийн газрыг хэн нэгэн хүн бус бүх нийтээр хүлээн зөвшөөрч хамтран тогтоосон эрх зүйн баримт бичиг болох Үндсэн хуулийн дагуу цогцлоон бий болгож, тэрхүү хууль, дүрэм, журам нь хүн бүрд тэгш үйлчилж байх явдал юм |
| Үндсэн хуулийн суурь зарчим | Хүний эрхэм чанар | Хүний эрх | Эрх зүйд захирагдах ёс |

| **Иргэний эрх зүйн харилцааны объект** | **Гэрээ** | **Иргэний эрх зүйн харилцааны субъект** | **Иргэний эрх зүйн бүрэн чадамж** |
|---|---|---|---|
| Хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүд үр дагаврыг бий болгох байдлаар харилцан тохиролцож хийсэн бичвэрийг хэлнэ. | Иргэд хоорондын эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээд. | Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, мөн эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх багтана. | 18 наснаас эхлэн бий болдог чадамж. |
| | | | |

2. Дараах жишээг уншаад нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа гэж юу болох, хэн хамаарахыг тодорхойлон бичээрэй.

Манай өвөө өндөр настны тэтгэвэр авдаг.

Орон тооны илүүдлээр ажилгүй болсон тул тэтгэмж авсан гэж ах ярьж байлаа.

Сумын халамжийн ажилтан манай эгчид тэргэнцэр өгсөн.

Би шүдний эмнэлэгт үзүүлсэн.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*

*Дууссан: Он, сар, өдөр*

3. Зааврын дагуу ажиллаарай.

3.1. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү?

.........................................................................Төрийн байгууллага албан тушаалтанд гомдол гаргах, мэдээлэл хайх, цуглуулах, улс төрийн нам байгуулах, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх,

................... Нийгэмд эзлэх байр сууръ, албан тушаал, анги, давхарга, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, бэлгийн чиг баримжаанаас үл хамаарч, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

..................... Үнэн зөв байх, онол, арга зүй, практикийн бодит үнэнд шүтсэн, зөвийг дээдэлж энэрэн хүндэтгэж, хөхиүлэн дэмждэг, бурууг ялган салгаж жигшин зэвүүцэж чаддаг байх,

..................... Өөрийн улсад амьдарч аж төрж байгаа үндэстэн, ястан, овог, аймгийн эв эеийг хангах,

.................... Үндсэн хуулийг хүндэтгэн биелүүлэх, төрийн бусад хууль тогтоомжийг Үндсэн хуулийг биелүүлэн хэрэгжүүлэхэд нийцүүлэх, хуулийг дээдлэхийн тулд төр, иргэн хоёр харилцан хариуцлага хүлээх

3.2. Дээрх мэдээллийг нийтэд нь ямар ойлголтоор тайлбарлавал зохилтой вэ? Өгөгдсөн ойлголтуудаас тохирохыг сонгон * тэмдгээр тэмдэглээрэй.

1. Үндсэн хуулийн заалт, 2. Үндсэн хуулийн үзэл баримтлал, 3. Үндсэн хуулийн суурь зарчим, 4. Үндсэн хуулийн нэр томьёо, 5. Үндсэн хуулийн тайлбар

4. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхөж бичнэ үү?

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг захиргааны шийтгэл гэнэ. Зөрчлийн тухай хуульд заасанаар дараах шийтгэлийг зөрчил гаргасан этгээдэд оногдуулна. Үлдсэн нэг шийтгэлийн төрлийг тэмдэглэнэ үү.

a) Торгох
b) Баривчлах
c) .............

5. Дараах тодорхойлолтыг гүйцээн бичиж, уг тодорхойлолтод хамаарах нэг жишээ гаргана уу.

Эрх зүйд захирагдах ёс гэдэг нь
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................
Жишээ нь:
..........................................................................................................
..........................................................................................................
.............................. ............................................................................

*Бүлэг сэдэв:*

I | **II** | III

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

## 6. Эх сурвалжтай ажиллаарай.

Эх сурвалж 1: Монгол улсын Үндсэн хууль 17.2.

Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэний үндсэн үүрэг болохыг заасан.



Эх сурвалж 2: Эрүүгийн хууль 6.1.3

Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.

Эх суралж 3: Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1-р зүйл




Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. 5-р зүйл. Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харилцах, шийтгэх ёсгүй.

Эх суралж 4: Зөрчлийн тухай хууль 6.21.1.

Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

1. Эх сурвалжид нийтлэг ямар асуудлыг хөндсөн байна вэ?

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

2. Уг асуудал нь хүний эрхэм чанартай хэрхэн холбогдож байгааг эх сурвалжид тулгуурлан 1-2 жишээгээр тайлбарлаарай.

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

3. Хүний нэр төр, хүний эрхэм чанар, эрх зүйд захирагдах ёс гэсэн ойлголтуудын уялдаа холбоо, ялгааг венийн диаграммаар зураглаарай.



*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

## 7. Тохиолдол шинжлээрэй.

"Нийгэм судлал X" Сурах бичгийн 70-71 дах талаас даалгавар 22, 24"-ыг уншаад нийгмийн даатгал, халамжийн харилцаанд оролцох гол үндэслэлүүдийг тайлбарлан бичээрэй.

## 8. Эхийг анхааралтай уншаад доорх асуултад хариулаарай.

Иргэн Б 2020 онд газар авч аймгийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 255 тоот захирамжтай газар эзэмшигч боловч ашиглаагүй нэг жил болжээ. Тэрээр газар дээрээ очтол иргэн Д газар дээр нь хашаа барьсан байв. Харин иргэн Д мөн газар эзэмших гэрчилгээтэй.

Асуулт 1. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч "хэргийн оролцогч" гэсэн субьектэд аль нь хамаарлгүй вэ?
a) Гомдол гаргаж буй иргэн
b) Гэрч
c) Хуулийн этгээд
d) Хариуцагч

Асуулт 2. Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг иргэн Б эс зөвшөөрч захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргах болжээ. Иргэн Б нэхэмжлэлдээ юуг хавсаргах вэ? Зөвийг тэмдэглээрэй.

| | |
|---|---|
| 1 | Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсвэл чөлөөлөгдөх хүсэлт, түүнийг нотлох баримт |
| 2 | Өмгөөлөгчийн мэдээлэл |
| 3 | Хавсаргасан баримт бичгийн жагсаалт |

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

9. Хөдөлмөрлөх нь хүний эрх үү, эсвэл үүрэг үү ? Асуултын хариултыг 2-3 үндэслэлээр тайлбарлан бичээрэй.

10. “Нийгэм судлал X” 2019 оны Сурах бичгийн 61-63 дахь талаас хөдөлмөрийн гэрээ байгуулахтай холбоотой мэдээллийг уншаад дараах хүснэгтийг нөхөн бичээрэй.

| Чухал санаа | Дэлгэрүүлэн судлах, асуух зүйл |
|---|---|
| ✓ | ✓ |
| ✓ | ✓ |
| ✓ | ✓ |
| ✓ | ✓ |
| ✓ | ✓ |
| ✓ | ✓ |

11. Үндсэн хууль хичээлийн бичлэгийг үзээд дэвтэртээ тэмдэглэл хөтлөөрэй.
Хичээлийн холбоос: https://www.youtube.com/watch?v=vk1TFCtbzKU

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________

*Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

12. Тохиолдол шинжлээрэй.

*Тохиолдол 1*. Манай ангийн найз маань 16 настай бөгөөд хичээлийнхээ хажуугаар цагийн ажил хийн хуримтлуулсан мөнгөө ахын хүнсний дэлгүүрт өгч өсгөхийг хүссэн боловч эцэг, эх нь зөвшөөрөөгүй байна.
*Тохиолдол 2*. Би өөрийн унадаг дугуйг найздаа 250,000 төгрөгөөр зарсан. Манай ээж, аав намайг 17 настай, насанд хүрээгүй учир бие даан шийдвэр гаргах боломжгүй гэж үзэн худалдах, худалдан авах гэрээг хүчингүйд тооцож, унадаг дугуйг буцаан өгөхийг найзаас маань шаардсан.
*Тохиолдол 3.* Иргэн А нь сэтгэцийн өвчтэй учраас үйлдлийнхээ учир холбогдлыг сайн ойлгодоггүй. Түүний нөхөр С энэ байдлыг нь мэддэг тул А-ийн нэр дээр байсан 3 га газрыг өөрийн нэр дээр гарын үсэг зуруулан, шилжүүлэн авч заржээ. Энэ байдлыг мэдсэн А-ийн ээж шүүхэд хандан гомдол гаргасан байна.

**Ажлын хуудас**

| Шинжлэх асуултууд | Тохиолдол 1 | Тохиолдол 2 | Тохиолдол 3 |
|---|---|---|---|
| Тохиолдол тус бүрийн иргэний эрх зүйн харилцааны бүрдэл хэсгүүдийг тодорхойлно уу? | | | |
| Тухайн тохиолдол дээр иргэний эрх зүйн харилцаа ямар үндэслэлээр үүсэж байгааг тайлбарлана уу? | | | |
| Тохиолдолыг хэрхэн шийдвэрлэх боломжтой байна вэ? | | | |

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

13. Зааврын дагуу ажиллаарай.

13.1. “Иргэн ба захиргаа хоорондын харилцаа” цахим хичээлийг дараах холбоосоор үзэж дэвтэртээ тэмдэглэл хөтлөөрэй. Хичээлийн холбоос: https://www.youtube.com/watch?v=CPo6dzGGE9I.

13.2. Дараах мэдээллүүдийг уншаад иргэн ба захиргаа хоорондын харилцаатай холбоотой чухал гэж бодож байгаа нэг ойлголтыг сонгож яагаад сонгосон үндэслэлээ тайлбарлан бичээрэй.

Мэдээлэл 1

Иргэд захиргааны байгууллагатай харилцахдаа тодорхой эрх эдэлж түүнтэй холбоотой үүргийг хэрэгжүүлдэг. Захиргааны байгууллага ч иргэний эрхийг хангах, холбогдох үүргийг хүлээж байдаг.



Иргэний мэдэх эрх буюу мэдээлэл олж авах, хүртэх эрх нь Монгол улсын Үндсэн хууль болон мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажсан байдаг. Иргэнд захиргааны байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзвал гомдол гаргах эрхтэй байдаг. Иргэн гомдлоо дээд албан тушаалтанд нь хандан амаар болон бичгээр гомдол гаргах, Захиргааны хэргийн шүүхэд хандах шат дараалаар шийдвэрлүүлэх эрхтэй.

Мэдээлэл 2

Хүснэгт 1. “Иргэний эрх, захиргааны үүргийн харилцан хамаарал”

| Иргэн | Захиргаа |
|---|---|
| Хүний эрх, эрх чөлөө | Захиргааны шийдвэр, үйл ажиллагаа |
| Өргөдөл, гомдол гаргах эрх | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүрэг |
| Мэдэх эрх | Хүссэн мэдээллийг өгөх үүрэг |

............................................................................................................
............................................................................................................
............................................................................................................
............................................................................................................
............................................................................................................
............................................................................................................
............................................................................................................

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________  *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусссан: Он, сар, өдөр*

**14. Зааврын дагуу ажиллаарай.**

14.1. Дараах эх сурвалжуудаас нэгийг сонгон судалж өгөгдсөн асуултад хариулаарай.

- Сурах бичиг хуудас 51-52 дугаар талын мэдээлэл
- Эх сурвалж: http://mn-nhrc.org/index.php?newsid=535
- Хүний эрх гэж юу вэ? хичээлийн агуулгыг “Нийгмийн ухааны нэвтэрхий толь ” youtube сувгаас үзэж судлаарай. https://www.youtube.com/watch?v=tz0fkRXPfmg
- Энэ QR кодыг уншуулах

14. 2. Өөрийн судалсан эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан хүний эрхийн ойлголтын үүсэл, хөгжлийг он цагийн хэлхээгээр гаргаарай.



14.3. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг заалт тус бүрийг зургаар илэрхийлснийг энэ холбоосоор үзэж Постер бэлтгэн ангийнхандаа танилцуулаарай.
https://nhrcm.gov.mn/international-human-rights-day-2019/#&gid=1&pid=1

14. 4. Хүний эрхийн тухай ойлголтыг хүний эрхэм чанартай холбон ойлгон хэрэгжүүлэхийн чухлыг илэрхийлсэн эссэ бичээрэй. Эссэ бичихдээ дараах мэдээллийг ашиглаарай. Үгийн тоо 500-650.

Хүний эрхэм чанар нь хүний эрхтэй шууд холбоотой байдаг. Хүний эрхэм чанар бол хүний эрх, эрх чөлөөний үндэс юм. Эрхэм чанарын тодорхойлолт оруулбал

- Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг.
- Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болдоггүй.
- Хүний эрхэм чанарт халдаж болохгүй.
- Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл.

## 15. Тохиолдол шинжлээрэй.

Лхагвасүрэн геологийн компанид инженерээр 25 жил ажилласан. Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт эрс буурснаас болж түүний ажилладаг компани нь дампуурлын ирмэгт тулж бүх ажилчдаа цомхотгосон байна. Геологич Лхагвасүрэн 50 настай. Ажилгүй болсныхоо дараа ажил хайж олон газар өргөдөл гаргасан боловч мэргэжлээрээ ажиллах боломж олдсонгүй. Эцэст нь хөдөө орон нутгийн нэгэн компаниас мэргэжлийн бус, цалин багатай ажлын санал түүнд иржээ. Гэтэл хүүхдүүд нь сургуулиасаа шилжих сонирхолгүй тул тэрээр орон нутагт ажиллаж чадсангүй. Лхагвасүрэн ажлаас халагдаад 2 сарын хугацаанд олгодог ажилгүйдлийн тэтгэмж, хадгаламжид байсан мөнгөө хэрэглэж дуусаад аргагүйн эрхэд халамжийн тэтгэмж хүссэн өргөдөл гаргажээ.

1.Тохиолдолд ямар асуудлыг хөндсөн байна вэ?
2. Асуудлыг шударга ёсны зарчмын үүднээс дүн шинжилгээ хийнэ үү.
3. Асуудлаас ямар, ямар үр дагавар бий болсон бэ?
4. Тохиолдлыг шийдэх ямар хууль эрх зүйн орчин манай улсад байна вэ?

## 10-3. “Хүний эрх” хичээлийн бататгал

### 16. “Хүний эрхийн талбай”-г дараах алхмаар бүтээгээрэй.

*Алхам 1:* “Хүний эрхийн талбай” бүтээнэ.

- Аль болох богино хугацаанд ажиллахыг хичээнэ.Талбай бөглөхөд тусалсан хүмүүсийн гарын үсгийг тухайн хүснэгтийн нүдэнд зуруулна.
- Хүснэгтийг бүрэн бөглөөд “Бинго” хэмээн зарлаж, бусдадаа мэдэгдэнэ.

*Алхам 2:* Бүтээсэн “Хүний эрхийн талбай”-гаа ангиараа хэлэлцээрэй.

- Аль талбайг бөглөх нь хамгийн хялбар, бас хэцүү байсан бэ?
- Аль талбай нь дэлхий нийтэд хамаарах асуудал байсан бэ?
- Аль талбай нь манай улсад анхаарах ёстой асуудал байна вэ?

*Алхам 3.*“Хүний эрхийн талбай” хүснэгтийн 3-4 асуултыг сольж бүтээгээрэй**.**

**Хүний эрхийн талбай**

| | | | |
|---|---|---|---|
| Хүний эрхийг ............... заасан үндэслэлээр хязгаарладаг. | Таны хувьд хамгийн чухал эрх | Хүний эрхийг баталгаажуулсан баримт бичиг | Тохиолдолд гарч буй иргэн Лхагвасүрэнгийн хамгийн их зөрчигдсөн эрх |
| Хүний эрхийн төлөө тэмцэгч Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллага | Хүний эрхийн тухай кино, жүжиг, ном | Хүний эрхийн төлөө тэмцэгч Монгол хүн | Хэрвээ чи иргэн Лхагвасүрэнгийн хүүхэд байсан бол чиний ямар эрх зөрчигдөх вэ? |
| Танд хамгийн их мэдрэгддэг хүний эрхийн зөрчил | Хүний эрхийн тухай уншсан номын нэр эсвэл агуулга | Иргэн Лхагвасүрэн эрхээ хамгаалахын тулд хамгийн түрүүнд юу хийх ёстой вэ? | Хэзээ ч хязгаарлаж болохгүй хүүхдийн эрх |

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*

*Дууссан: Он, сар, өдөр*

17. Заавриын дагуу ажиллаарай.

17.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцох зайлшгүй нөхцөл, шаардлага юу вэ? Сэдвийн хүрээнд бусадтай ярилцах асуулт боловсруулаарай.
17.2. Боловсруулсан асуултын дагуу ангийнхан, эцэг эх, найзуудтайгаа ярилцаж санал бодлоо солилцон өгөгдсөн загварын дагуу *бүтээлч тэмдэглэл* хөтлөөрэй.
17.3. Ярилцлагад үндэслэн *"Бидний эргэн тойрон дахь иргэний эрх зүйн харилцаа"* сэдвээр илтгэл бичих төлөвлөгөө боловсруулаарай.

## Бүтээлч тэмдэглэл хөтлөх хуудас

**Асуудал** — Иргэний эрх зүйн харилцаанд оролцох нь яагаад чухал вэ?

**Санаа 1** — Your text goes in here.

**Санаа 2** — Your text goes in here.

**Санаа 3** — Your text goes in here.

**Дүгнэлт** — Your text goes in here.

## Илтгэл бичих төлөвлөгөө боловсруулах хуудас



*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

18. Эх сурвалжтай ажиллаарай.

18.1. “Иргэний эрх зүй” хичээлийн бичлэгийг бие даан үзээд хичээлийн гол санааг тэмдэглээрэй. Хичээлийн холбоос: https://www.youtube.com/watch?v=Q_tdLrm8Q_0

## Тэмдэглэл бичих хуудас

| Түлхүүр үг, ойлголт | Гол санаа |
|---|---|
| Гол санаа | Асууж, тодруулах зүйл |

18.2. “*Бидний эргэн тойрон дахь иргэний эрх зүйн харилцаа”* сэдвээр илтгэл бичих төлөвлөгөө боловсруулсны дагуу илтгэл бичээрэй. Илтгэл бичихдээ дээрх цахим хичээлийн гол санаа, агуулга болон дараах зургуудыг эх сурвалж болгон ашиглаарай.














10-4-Эдийн засаг

| I | II | III |
|---|---|---|

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

1. Дараах тодорхойлолтыг анхааралтай уншиж 2 түлхүүр үгийг онцлон тайлбар бичээрэй.

Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг ДНБ гэнэ.

| Түлхүүр ойлголт | Тодорхойлолт, тайлбар |
|---|---|
| | |

2. Дараах хүснэгтийн хоосон зайг нөхөж бичээрэй.

| Ойлголт | Тодорхойлолт | Жишээ |
|---|---|---|
| Цалин | Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс | |
| Инфляци | | |
| Шилжилтийн ажилгүйдэл | Ажлаасаа гарч, дараагийн ажилд орох хүртэл хэсэг хугацааны ажилгүйдэл. | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл | | Барилга барих, тоног төхөөрөмж худалдан бусад үндсэн хөрөнгө худалдан авахад гаргасан зардал |
| Бүтцийн ажилгүйдэл | | Нэгэн хүнсний дэлгүүрт хяналтын камер суурилуулсан тул манай ах харуулаар ажиллахаа больсон. |
| ... ......................зардал | | Цэрэг, сурагч болон төрийн албан хаагчдад зориулан бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авах, сургууль эмнэлэг, зам гүүр зэргийг барихад гаргасан зардал |
| ... ........................... ажилгүйдэл | Эдийн засгийн уналтын үед ажилчид олноороо ажлаасаа халагдах үеийн ажилгүйдэл | |

10-4-Эдийн засаг

I | II | III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

3. Дараах мэдээллийг анхааралтай уншиж 2 түлхүүр үг эсвэл ойлголтыг онцлон тайлбар бичээрэй.

Санхүүгийн зах зээлд мөнгө, үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа явагддаг бөгөөд түүнийг хөрөнгийн ба мөнгөний гэж ангилна. Санхүүжилт хэрэгтэй байгууллагууд хувьцаа, бонд зэрэг үнэт цаас гаргадаг бол мөнгөө өсгөж ашиг олох гэсэн иргэд тухайн хувьцаа, бондыг худалдан авах замаар тэдэнд хөрөнгө оруулалт хийдэг. Ийм арилжаа хөрөнгийн бирж дээр явагдана. Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах эрхийн бичгийг нийтэд нь үнэт цаас гэж нэрлэнэ.

| Түлхүүр ойлголт | Тодорхойлолт, тайлбар |
|---|---|
| | |

4. Дараах 2 ойлголтыг вен диаграммаар илэрхийлэн бичээрэй.



10-4-Эдийн засаг



*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

5. Дараах өгүүлбэрт хамаарах ойлголтын зураглал гаргаарай.

Эдийн засгийг улс орны хэмжээнд хэмжих үзүүлэлтүүдийг “ойлголтын зураглал”-аар илэрхийлээрэй.

6. Сурах бичгийн даалгавар 26-д өгөгдсөн зургийг ажиглаад дараах заасврын дагуу ажиллаарай.

6.1. Асуултад хариулаарай.

a) Инфляцийг яагаад шаар үлээж байгаа хүнээр төлөөлүүлэн дүрсэлсэн бэ?

b) Шаарны хэмжээ болон шаар үлээж байгаа хүний биед ямар гарч буй өөрчлөлтөөр ямар утга санааг илэрхийлж байна вэ?

6.2. “Инфляцийн түвшин, хувь” зурган мэдээллийг тайлбарлан бичээрэй.




.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................
.........................................................................

10-4-Эдийн засаг

I II III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

7. Өгөгдсөн мэдээллийг ашиглан графикийн дүрслэлийн нэрийг хоосон зайд бичээрэй.

Статистикийн график дүрслэлийг түүнийг байгуулж байгаа аргаас хамааруулан хоёр ангилна. Үүнд:

1. Диаграммууд:
   a) Шугаман диаграмм (шулуун ба муруй шугаман);
   b) Талбайн диаграмм(Баганан, туузан, тойрог, сектор, тэгш өнцөгт, фонон, цэгэн, радиалан, дүрсэн диаграммууд);
   c) Гурван хэмжээст диаграмм;
2. Картограмм ба Картодиаграмм







______________________ ______________________







______________________ ______________________

10-4-Эдийн засаг

I | **II** | III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

8. Зааврын дагуу ажиллаарай.

8.1.Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар судалж хүснэгтэд тэмдэглээрэй.

| № | Санхүүгийн Байгуллагууд үзүүлэлтүүд | Арилжааны банк | Хадгаламж зээлийн хоршоо | Даатгалын компани | Барьцаалан зээлдүүлэх газар | Банк бус санхүүгийн байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилго | | | | | |
| 2 | Үзүүлэх үйлчилгээ | | | | | |
| 3 | Үйл ажиллагааны онцлог | | | | | |

8.2. Санхүүгийн байгууллагаа зөв сонгоход нь туслаарай.

А. Сугармаа сүүлийн нэг жил дэлгүүр ажиллуулж байгаа. Дэлгүүрийнхээ орчныг тохижуулах, засварлах зорилгоор санхүүгийн байгууллагаас зээл авахаар шийджээ. Банк эсвэл банк бус санхүүгийн байгууллагын алинаас зээл авах нь ашигтайг Сугармаад зөвлөнө үү. Мөн ямар сул тал байж болохыг тайлбарлаж өгөөрэй. Сугармаа хадгаламж зээлийн хоршооноос зээл авч болох уу?

**Б.** Очир зуныхаа амралтаар ахынхаа компанид туслах ажилтнаар ажиллаж 900000 ₮ ажлын хөлсөнд авчээ. Мөн өөрийн хуучин гар утсаа 70000 ₮ -өөр зарсан. Болд энэ жил 12-р ангид суралцах бөгөөд 11 сарын 30 гэхэд шинээр *Iphone 7 s* утас худалдан авах зорилгоор мөнгөө хадгаламжинд байршуулах шийдвэр гаргажээ. Болдод санхүүгийн байгууллагаа сонгоход нь зөвлөгөө өгнө үү.

Сугармаад өгөх зөвлөгөө

Очирт өгөх зөвлөгөө

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ______________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусан: Он, сар, өдөр*

9.Зааврын дагуу ажиллаарай.

9.1. Тухайн улс жилийн турш зөвхөн 2 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэж үзвэл энэ улсын эдийн засгийн өсөлтийг тухайн онуудад хэдий хэмжээгээр өссөн болохыг тооцно уу.

| | | 2019 он | | 2020 он | |
|---|---|---|---|---|---|
| № | Төрөл | Үнэ $(P_i)$ | Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг $(Q_i)$ | Үнэ $(P_i)$ | Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг $(Q_i)$ |
| 1 | Талх | 1050 | 1000.0 | 1100 | 1600.0 |
| 2 | Ургамлын тос | 3500 | 500.0 | 2300 | 850.0 |

Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томьёог ашиглаарай.

$$ДНБ = \sum P_i Q_i = P_1Q_1 + P_2Q_2 \qquad ДНБ-ий\ өсөлт = \frac{ДНБ_{2020}}{ДНБ_{2019}} \times 100\%$$

Томьёоноос ДНБ-ий өсөлтөд үйлдвэрлэсэн баялгийн биет хэмжээний болон тэдгээрийн үнийн өсөлт гэсэн хоёр хүчин зүйл зэрэг нөлөөлж байгааг ажиглагдаж байна.

9.2. Үнэ болон бүтээгдэхүүний биет хэмжээ хэдэн хувиар өссөн бэ? Бидний амьдралд аль үзүүлэлтийн өсөлт чухал вэ? Яагаад гэсэн асуултын дагуу бусадтай санал солилцон тэмдэглэл хөтөлж, дүгнэлт гаргаарай.



Тэмдэглэл бичээрэй.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*

*Дууссан: Он, сар, өдөр*

10. Зааврын дагуу ажиллаарай.

10.1. Инфляцийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллүүдээс манай оронд илт ажиглагдаж байгаа нөлөөлөл чиний бодлоор аль вэ? Нөлөөллийг хамгийн ихээс бага нөлөөлөл үзүүлэх дараалаар дугаарлана уу.




10.2. Инфляцийн нөлөөллийг дугаарласнаа сүүлийн 3 сарын статистик мэдээлэлд тулгуурлан нотлон тайлбарлаарай.

Ашиглаж болох эх сурвалж: https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Brochures.2021..pdf&ln=Mn

10.3. Дараах асуултын дагуу бусадтай санал солилцоорой.

- ✓ Хүмүүс хурдтай инфляцийн үед гадаад валют хуримтлуулахыг эрмэлздэг. Үүний шалтгаан нь юу вэ?
- ✓ Хүмүүс хурдтай инфляцийн үед алт худалдан авах нь элбэг тохиолддог. Үүний учир юунд байна вэ?

10.4. Их хурдтай инфляцийн үед хувь хүн эрсдэлээс өөрийгөө хамгаалахын тулд ямар үйлдэл, шийдвэр гаргах ёстой, “Инфляциас хэн хохирч, хэн хожиж болох талаар зөвлөмж бичээрэй. Зөвлөмж бичихдээ:

- https://1212.mn/sonirkholtoi/ цахим хуудсаар зочилж мэдээлэл аваарай.
- Инфляцийн тухай хичээлийн агуулгыг “Нийгмийн ухааны нэвтэрхий толь” youtube сувгаас үзэж судлаарай. Холбогдох линк: https://www.youtube.com/watch?v=1ud6Pjlnfo4&t=357s

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________

*Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

11. Зааврын дагуу ажиллаарай.

11.1. Дараах үйлчилгээг ямар санхүүгийн байгууллагаас авах вэ? Үүнийг √ тэмдэглэж, үндэслэлээ тайлбарлан бичээрэй.

| № | Санхүүгийн Байгуллагууд Үйл ажиллагаа | Арилжааны банк | Хадгаламж зээлийн хоршоо | Даатгалын компани | Барьцаалан зээлдүүлэх газар (ломбард) | Банк бус санхүүгийн байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зээл авах шаардлагатай болох | | | | | |
| 2 | Төлбөрийн картаасаа бэлэн мөнгө авах | | | | | |
| 3 | Гадаад улсаас гэртээ мөнгө гуйвуулах | | | | | |
| 4 | Нэг хоногийн хугацаатай бага хэмжээний бэлэн мөнгөний хэрэгцээ гарах | | | | | |
| 5 | Хадгаламж зээлийн хоршооны гишүүнд зээлийн хэрэгцээ гарах | | | | | |
| 6 | Япон улсаас авто машин оруулж ирэх | | | | | |
| 7 | “Эрдэнэс таван толгой” ХК-ний 300 000 төгрөгний хувьцааг Засгийн газарт худалдаж, мөнгөө авах | | | | | |
| 10 | Худалдан авалтын төлбөрийг зээлийн эрхтэй картаар хийх | | | | | |

11.2. Дараах асуултад хариулаарай.

1. Санхүүгийн зуучлалтай болон санхүүгийн зуучлалгүй эдийн засгийн ялгаа юу вэ?
2. Иргэд өргөнөөр оролцох боломжтой санхүүгийн зах зээлийг нэрлэж, учир шалтгаан юу вэ?
3. Манай улсын хувьд банкны салбар давамгайлан хөгжихөд юу нөлөөлсөн байж болох вэ?
4. Хөрөнгийн хоёрдогч зах зээлийн арилжаанд иргэд оролцож болохгүй гэдэгтэй та санал нийлэх үү? Яагаад? Учир шалтгаан юу вэ?
5. Хувь хүн, өрхийн хувьд санхүүгийн зах зээлд оролцсоноор ямар давуу талууд бий болох вэ?

11.3.Санхүүгийн байгууллагуудыг хэрхэн сонгох, юу анхаарах талаар иргэдэд зориулсан зөвлөмж бичээрэй. Зөвлөмж бичихдээ 11.1 болон 11.2 даалгаврын хариултыг ашиглаарай.

10-5. Улс төр

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусган: Он, сар, өдөр*

1. Дараах ойлголтуудыг Ардчилал ба хүний эрх сэдэвтэй холбон тайлбарлаарай.

- Чөлөөтэй сэтгэн бодох
- Санасан бодсон үгээ хэлэх
- Дуртай газараа амьдрах
- Дуртай хувцсаа өмсөх
- Уран бүтээл туурвих
- Дуртай газраа явах
- Найз нөхдөө явах
- Найз нөхрөө чөлөөтэй сонгох
- Хувийн өмчтэй байх
- Бизнес эрхлэх
- Сонголт хийх
- Санал дэвшүүлэх
- Өөрчлөлт хийх
- Ёс заншил уламжлалаа дагах
- Түүхээ мэдэх
- Газар эзэмших

2. Дараах мэдээллийг анхааралтай уншиж 2 түлхүүр үг эсвэл ойлголтыг онцлон тайлбар бичээрэй.

Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ.

1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

3. Монгол улсын үндсэн хуулийн заалт өгөгджээ. Анхааралтай уншиж тайлбар, ойлголттой нь зөвөөр харгалзуулаарай.

| | |
|---|---|
| • Иргэний | Хүний сайн сайхны төлөө |
| • Ардчилсан | Бүгд эрх тэгш ,адил |
| • Хүмүүнлэг | Иргэн нь шийдвэр гаргадаг |
| | Төр нь биелүүлдэг |

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________

*Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

4. Дараах хэлсэн үгийг уншаад ардчиллын тулгуур үнэт зүйлийг тайлбарлаарай.

*Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө ард түмний өөрсдийнх нь засаглал юм. А.Линкольн*

5. Дараах зургийг ажиглаад зөв тайлбартай нь тохируулаарай.







Ардчиллын хэлбэр

Төлөөллийн ардчилал

Шууд ардчилал

Ардчиллын төрөл

6. Дараах мэдээлэл чиний судалсан ямар агуулгатай холбогдож байна вэ? Тайлбарлаарай.

- **Нээлттэй** – төрийн үйл ажиллагаанд иргэд оролцох боломж нээлттэй байх
- **Шударга байх** – иргэдэд тэгш эрх олгодог байх
- **Хууль дээдлэх** – бүх хүн, бүх байгууллага хуулийг дагаж мөрдөх
- **Зөвшилцөх** – өөр өөр үзэл бодлыг хүлээн зөвшөөрч аливаа асуудлыг зөвшилцөж шийдвэрлэх
- **Цөөнхийг хүндэтгэх** – асуудлыг олонхын саналаар шийдвэрлэх хэдий ч цөөнхийн үзэл бодлыг хүндэтгэх

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

7. 1989 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Монголын Ардчилсан Холбоо (МоАХ)-ны анхны цуглааны талаарх мэдээллийг уншаад өгөгдсөн асуултын дагуу ярилцаарай.

**“Хүний эрхийн өдрөөр жагссан нь”**

... 1989 оны 12 дугаар сарын 10-ны өдөр МоАХ-ны анхны цуглаан Залуучуудын соёлын төвийн өмнөх талбайд боллоо. Олон улсын Хүний эрхийн өдрийг онцлон сонгож хийсэн энэ цуглаанаас МоАХ байгуулагдсаныг олон түмэнд албан ёсоор зарласан байна. Мөн МАХН-ын Төв хорооны VII бүгд хурал, АИХ-ын VIII чуулганд хандаж 13 зүйлт улс төрийн шаардлага бүхий МоАХ-ны “Өргөн барих бичиг”-ийг цугласан олонд уншиж танилцуулжээ. Тэр цуглаан бол нийслэлд болсон ардчиллын төлөө, олон хүн хамарсан анхны цуглаан байлаа.

...Дотоод, гадаадын хэвлэл мэдээллийнхэн, сэтгүүлч, сурвалжлагч олноороо цугласан эл цуглаанд оролцогсод “Эрх зүйт төрийн төлөө”, “Ардчилал бидний зорилт”, “Хүнд суртлын аппаратыг устгая”, “Хүний эрхийг дээдэлье”, “Тусгай хангамж бол хахууль”, “Solidarity for Human rights”, “Олон намын тогтолцоо” “We support Perestroika and Glasnost” зэрэг уриа лоозон барьцгаасан байжээ.
*Эх сурвалж: Яагаад ардчилал гэж... Иргэний боловсрол төв.УБ.,2012. 18 дахь тал.*

Дээрх эх сурвалжид юуны тухай өгүүлж байна вэ?

1. Яагаад Олон улсын Хүний эрхийн өдрөөр жагссан бэ?
2. М оАХ жагсаалыг ямар зорилгоор зохион байгуулсан бэ?
3. Тухайн үед жагсаал зохион байгуулах боломжтой байсан уу? Тухайн цаг үеийн талаар ярилцана уу?
4. Цуглаанд оролцогчдын дэвшүүлсэн уриа, лоозон ямар үзэл санааг илэрхийлж байна бэ?
5. Уриалж байсан үзэл санаа өнөөдөр бидний амьдралд хэр биеллээ олсон талаар санал бодлоо хуваалцаж, хэлэлцүүлэг өрнүүлээрэй.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

8. Ардчилал, Монгол улсын үндсэн хуультай холбоотой агуулгаар үгийн сүлжээ бөглөөрэй.



**Хэвтээгээр:**

1. Эх орноо … нь иргэн бүрийн заавал биелүүлэх үндсэн үүрэг юм.
3. Иргэн бүр ажил мэргэжлээ … сонгоно.
4. 1990 онд Ардын Их Хурлыг сонгох анхны ардчилсан … болжээ.
5. … хамгийн дээд хүчин чадалтай, хамгийн гол хууль юм.
8. Эрэгтэй, эмэгтэй бүх хүн … эрхтэй.
9. … бүр үндсэн үүргээ заавал биелүүлэх ёстой.
10. Иргэн бүрийн биелүүлэх журамт үүргийн нэг нь … орчноо хамгаалах юм.
12. Үндсэн хуулийн 2-р бүлэгт Монгол Улсын иргэн бүрийн эдлэх эрх, …, хүлээх үүргийг тогтоосон.

**Босоогоор:**

2. 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хуулиа "…" гэж тодотгон нэрлэдэг.
6. Хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт … юм.
7. Монгол Улсын Үндсэн хууль "Мэдэгтүн, …" гэж дуусдаг.
11. Иргэн бүр сурч … эрхтэй.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________

*Эхэлсэн: Он, сар, өдөр*

*Дууссан: Он, сар, өдөр*

9. Дараах зурган мэдээллийг ашиглан Ардчиллын үнэт зүйлс ба Монгол улсын Үндсэн хууль сэдэвт эх зохион бичээрэй.

Ашиглах эх сурвалж:
https://www.youtube.com/watch?v=vk1TFCtbzKU&t=104s






10. Парламент хэрхэн үүссэн бэ? Дараах 3 мэдээллийг дэлгэрүүлэн судалж мэдээлэл бэлтгэн бусдадаа танилцуулаарай.

1



*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусан: Он, сар, өдөр*

2

1200-аад онд Англи улсыг эзэн хаан Жон удирдаж байв. Тэрээр газрын эзэд болон жирийн ардуудаас их хэмжээний татвар авч, өөрийнх нь эсрэг тэмцсэн хүмүүсийг шоронд суулгадаг харгис хаан байв. Газрын эзэд Жон хааны хязгааргүй эрх мэдлийг эсэргүүцэж, түүний эсрэг тэмцэл өрнүүлжээ.Тэмцлийн дүнд Жон хаан газрын эздэд аргагүйн эрхэнд бууж өгчээ.

1215 онд Жон хаан нь эрх мэдлийг нь хязгаарлах тухай “Магна Харта” гэх баримт бичигт гарын үсэг зуржээ.



1246 онд буюу Магна Хартаг батлснаас 30 жилийн дараа хааны дэргэд байгуулагдсан хурлыг “Парламент” гэж нэрлэх болжээ.

1295 онд Эдуард хаан Парламентад Английн гүн, ноёдоос гадна тайж, хотын иргэдээс сонгож оролцуулах болсноор “Төлөөллийн Парламент” бий болжээ.

3



11. Монгол улсын хууль тогтоох дээд байгууллага- Улсын их хуралтай холбоотой мэдээллийг нэмэлт мэдээлэл судалж *Таны мэдлэгт* постер бэлтгэн танилцулаарай.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

12. Монгол дахь ардчиллын үнэт зүйлсийн талаарх дээрх иргэний ба улс төрийн эрх, эрх чөлөө, авлигын талаарх олон улсын судалгаанд үндэслэн эссэ бичээрэй. Эс ээ бичхдээ үүнтэй адил судалгаа, эх сурвалж, илтгэл зэрэг материалууд ашиглаарай.

**Монгол дахь ардчиллын хөгжлийн талаарх үнэлгээний тойм**

Фрийдом хаус байгууллага НҮБ-ын гишүүн 193 улсад хүний эрх, эрх чөлөө ямар байгааг судалж дүгнэлт гаргадаг Төрийн бус байгууллага юм. Тус байгууллагын 2016 оны судалгаагаар Монгол улс 1.5 гэсэн үзүүлэлтээр “чөлөөт” буюу эрх чөлөөтэй гэсэн ангилалд багтаж байна. Энэ нь 2001 онд “хагас чөлөөт” ангилалд багтаж байсантай харьцуулбал Монгол улс ардчилсан, эрх чөлөөт орон болж хөгжжээ. Монгол улсын энэхүү үзүүлэлт нь хүний улс төрийн болон иргэний эрхийн хэрэгжилтийг илэрхийлж байгаа юм. Уг судалгаагаар улс төрийн эрх, эрх чөлөөнд хамаарах үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвсэн нэгдэх зэрэг суурь эрх чөлөө өнөөдөр бүрэн хангагдсан. Харин төрийн үйл хэрэгт оролцох, эрх баригчдад нөлөө үзүүлэх, хяналт тавих зэрэг эрхээ хэрэгжүүлэх боломж, иргэдийн өөрсдийн нийгэмшилт, төрийн идэвхгүй байр сууриас төлөвшлөө олохгүй байсаар байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

Ардчилсан нийгэмд төр нь иргэддээ үйлчлэх гол үүрэгтэй ба энэ үйлчилгээ ил тод шаардлагад нийцэхгүй байх нь авлига дэлгэрэх гол нөхцөл болдог.

“Transparency International” байгууллагын Авлигын төсөөллийн индексээр Монгол улс авлигад өртсөн орнуудын тоонд багтжээ. Авлигын асуудал нь улс төр, эдийн засаг, нийгэм дэх эрүүл харилцааг бүхэлд нь доройтуулдаг ба Монгол улсын хувьд анхаарах асуудал байсаар байна. Учир нь 2016 оны байдлаар Монгол улс авлигын төсөөллийн индексээр 38 гэсэн оноогоор Дэлхийд 176 орноос 87-д эрэмбэлэгдэж байна.

13. *“Төрийн үйлчилгээ иргэдэд”* сэдвээр эссэ бичээрэй. Эссэ бичихийн өмнө дараах асуултын дагуу онолын мэдлэг, ойлголтоо бататгана уу.

1. Төрийн байгууллага иргэдэд хэрхэн үйлчлэх ёстой вэ?
2. Засгийн газар олон нийтийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллахын учир юу вэ?
3. Төрийн үйлчилгээг авахын тулд бид ямар үүрэг хүлээдэг вэ?
4. Дээрх баримттай ажиллаад төрийн үйлчилгээг хэрхэн ангилж болох талаар ярилцана уу.
5. Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх ямар арга замууд байж болох талаар саналаа солилцоорой.

10-6. Олон улсын харилцаа

I II III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:_____________*  *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

1. Дараах мэдээллийг уншаад  зөв тайлбартай нь тохируулаарай.

Олон улсын харилцааны улс оролцогч

- Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг.
- Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.
- Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг.

| Улс оролцогч | Их гүрэн | Дунд улс | Бага улс | Улс бус оролцогч |
|---|---|---|---|---|

2. Зөв харгалзуулна уу.

1.Олон улсын харилцаанд оролцох үүрэг нь :

2. Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааны чиглэл нь:

3. Олон улсын харилцаанд оролцох нөлөө нь :

А.ОУХ-нд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагаагаар оролцдог.
Б.Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх
В.Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдоно.

А. 1а2б3в    Б. 1в2а3б    В. 1с2б3в    Г. 1б2а3в    Д. 1а2в3б

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:____________* *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

3. Эх сурвалжийг уншаад асуултад хариулаарай.



Зураг 1: БНМАУ-ын НҮБ-д элсэж төрийн далбаагаа мандуулав. 1961 оны 10 дугаар сар.

БНМАУ-ын Засгийн газар 1946 оны 6 дугаар сарын 21-нд НҮБ-д гишүүнээр элсэх хүсэлтээ анх удаа гаргажээ. Уг хүсэлтэд БНМАУ нь НҮБ-ын дүрмийн бүхий л заалтыг тууштай дагаж мөрдөхөө илэрхийлжээ. БНМАУ 1949 оноос хойш Монголд болон дэлхий дахинд энхтайванч байдлыг тогтоох олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан ба энх тайванч санал санаачилга, идэвхтэй үйл ажиллагаа нь олон улсын анхаарлыг ихээхэн татаж байлаа. Манай улс тус байгууллагад элсэх хүсэлтээ 1948, 1955, 1956 онуудад гаргав. 1955 онд НҮБ-д элсэхээр өргөдөл өгсөн 18 улсыг нэгэн зэрэг элсүүлэх тухай Швед зэрэг 28 орны саналыг НҮБ-ын Ерөнхий ассамблей дэмжсэн байна. Гэвч Аюулгүйн зөвлөл уг асуудлыг хэлэлцэхэд Чан Кай Ши-гийн төлөөлөгч БНМАУ-д хориг тавьжээ. Харин хэдэн жилийн дараа БНМАУ, Мавритан хоёр улсыг НҮБ-д элсүүлэх тухай хэлэлцэж, улмаар социалист 11 улс, мөн Энэтхэг, Индонез, Ирак, Египет зэрэг 23 орны төлөөлөгчдийн хамтран оруулсан тогтоолын төслийг Ерөнхий ассамблейн XXVI чуулганаар хэлэлцээд БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнээр баталжээ. Одоо монгол улс энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож олон үүрэг гүйцэтгээд байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч ноён Дэвид Шийрэр хэлсэн үгэндээ “Та бүхний хөлс хүч, эр зоригийг үнэлэн өгч буй энэхүү медалийг биечлэн Бентью хотод ирж гардуулж өгөхийг хүссэн юм” гэжээ.

*Эх сурвалж: https://mongoltoli.mn/history/h/164*

1. БНМАУ НҮБ-д хэдэн онд элссэн бэ?
2. БНМАУ НҮБ-д элссэнээр олон улсын харилцааны улс оролцогчийн аль ангилалд орсон бэ?
3. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч ноён Дэвид Шийрэр өөрийн биеэр ирж хүндэтгэл үзүүлснийг ач холбогдлыг тайлбарлана уу?
4. Одоо Монгол улс энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож олон үүрэг гүйцэтгэж байна. Үүнийг жишээгээр тайлбарлаарай.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

4. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим, тэдгээрийн агуулгыг зөв харгалзуулаарай.

1.Олон тулгуурт байх

2. Прагматик байх

3. Тэнцвэртэй байх

4. Үндэсний эрх ашигт нийцсэн байх

a) Үндэсний эрх ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.
b) Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулна.
c) Нэг талаас Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулна.
d) Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дараалдлыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.

А. 1a2b3c4d Б. 1в2a3c4d В. 1c2a3в4d Г. 1c2b3d4a

5. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ” гэжээ. Энэ заалт оршин тогтнохуйн аюулгүй байдлын аль бүрэлдэхүүнд хамаарах вэ?

А. Нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал
Б. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал
В. Соёл иргэншлийн аюулгүй байдал
Г. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:____________* *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

6. Дараах эхийг анхааралтай уншаад өгөгдсөн асуултад хариулна уу.

АНУ-аас Хойд Солонгосын эсрэг хатуу хоригийн тогтоолын төслийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд танилцуулжээ. Энэ нь Аюулгүйн зөвлөлийн баталж байснаас хамгийн хатуу хориг болсон гэдгийг НҮБ дэх АНУ-ын суурин төлөөлөгч Саманта Пауэр мэдэгджээ. Тухайлбал, хоригт Хойл Солонгосын хөлөг онгоцны тээврийг нэг бүрчлэн хянаж, нисэх онгоцны шатахуун нийлүүлэхийг хориглож, зэвсгийн худалдааны хоригийг өргөжүүлэхээр заасан байна. Гэхдээ Хойд Солонгосын Хятадтай хийх худалдааг хоригт багтаагаагүй гэнэ. Хойд Солонгосын гадаад худалааны 80 хувь нь Хятад улстай хийгддэг. Хойд Солонгосын эсрэг хоригийг АНУ-ын тал хятадтай хэлэлцэж боловсруулсан юм.

*Эх сурвалж: News.mn 2016 оны 02 сарын 15*

1. *Эх сурвалжид дурдаж буй хоригийг ямар шалтгааны улмаас НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд АНУ танилцуулсан бэ? Өөрийн зөв гэж үзэж буй нэг хувилбарыг бичнэ үү.*
2. *Хойд Солонгос улсад эдүгээ улс төрийн ямар дэглэм байгаа вэ?*
3. *НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нь НҮБ-ын байгууллагууд дундаас гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх эрхтэй цорын ганц байгууллага бөгөөд байнгын 5 гишүүн оронтой юм. Эдгээр таван гишүүн оронд Хойд Солонгос багтдаг уу?*
4. *Олон улсын харилцаанд оролцогч субьектүүдэд үндэстэн улсуудын төр, засгийн газруудыг нэрлэдэг. Дээрх эхэд энэхүү ойлголтод хамаарах өгөгдөл байна уу?*

7. Хувь хүн олон улсын харилцааны улс бус оролцогч болдог. Орчин үед олон улсын харилцаанд тодорхой үүрэг чиглэлээр оролцож байгаа зарим хүмүүсийг дурьдахдаа хамааралгүй жишээ оруулсан бол аль вэ?

7.1. Өөрийн сонгосон жишээг тайлбарлан ярилцаарай.
7.2. Нэмж 2-3 жишээ бичээрэй.

A. НҮБ-ын энх тайвны элч, охидын боловсролын төлөө тэмцэгч Малала Юсуфзай 11 настайгаасаа эхлэн блог хөтөлжээ.
B. Wikileaks сайьыг үндэслэгч Жулиан Ассанж нь Панамын арлын Mossack Fonseca хуулийн фирмийн алдагдсан нууц материалыг ил болгосноор дэлхий даяар шуугиан тарьсан.
C. Эдвард Сноуден нь Пентагоны харьяа тагнуулын компианий экс ажилтан бөгөөд 2007 оноос хойш АНУ-ын тусгай алба иргэдийн утасны яриаг чагнадаг тухай мэдээлэл хийсэн.
D. АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп НҮБ-ын индэр дээрээс Хойд Солонгосыг заналхийлсэн үг хэлсэн.

| Сонгосон жишээний дугаар | Тайлбар |
|---|---|
| | |

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

## 8. Эх сурвалжийг шинжлээрэй.

Цөмийн зэвсэггүй бүс гэдэг нь тодорхой хэлэлцээрийн хүрээнд цөмийн зэвсэг хэрэглэх, турших, боловсруулах үйл ажиллагаа явуулахыг хориглосон улс, бүс нутгийг хэлдэг. 1967 онд Латин Америк болон Карибын тэнгисийн сав газарт цөмийн зэвсгийг хориглох тухай “Тлателолкогийн гэрээ” гарсан нь хамгийн анхны гэрээ билээ. Манай улс цөмийн зэвсэггүй статусаа олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргаж ажилласаар ирсэн. Энэхүү хүчин чармайлтын үр дүнд 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас дэмжсэн шийдвэр гаргуулж, 2012 онд Монгол Улс өөрийн газар нутгаа цөмийн зэвсгээс ангид бүс болгож зарласны 20 жилийн ойгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн таван гишүүн орон хамтарсан тунхаглал гаргаж Монгол улсын цөмийн зэвсгээс ангид бүсийг дахин баталгаажуулсан.

Эх сурвалж: http://eagle.mn/r/24997

8.1. Монгол улс цөмийн зэвсгээс ангид бүс нутаг болсны давуу талыг дурьдан бичээрэй.

8.2. Цөмийн зэвсэггүй бүс нутгийг зөвхөн хуурай газраар хязгаарлахгүй сансар орчин, далайн ёроолд хийхгүй гэсэн гэрээний заалтыг тайлбарлаарай.

8.3. “Цөмийн зэвсэггүй бүс” зурган эх сурвалжийг ашиглан даалгаврыг хийгээрэй.
А. Гэрээнд гарч буй улс, тивийг газрын зурагт улаан өнгөөр тэмдэглэл хийгээрэй.
Б. Хамрах хүрээнээс нэгийг сонгон улс төрийн газрын зурагт багтсан улсуудыг дэлгэрүүлэн тэмдэглээрэй.
В. Сансрын уудмын тухай гэрээг дэлгэрүүлэн судалж мэдээлэл бэлтгэн ангийнхандаа танилцуулаарай.




Эх сурвалж:eagle.mn

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

## 9. Эх сурвалжийг шинжлээрэй

| Эх сурвалж 1 | Эх сурвалж 2 |
|---|---|
| (Төслийн санхүүжүүлэгч: АДРА Канад болон Канадын үр тарианы банк.)<br>Төслийн гол зорилго нь цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, хахир хүйтэн урт өвөл, сэрүүхэн богино зуны улиралтай уулархаг бүс нутагт аж төрж буй нийгмийн эмзэг бүлгийн 880 өрхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулж хоол тэжээлийн чанарыг нэмэгдүүлэх болон амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд оршино.<br>Эх сурвалж: https://adra.org.mn/project-details/project2 | Монгол Улсын Засгийн Газраас Швейцарын хөгжлийн агентлаг, дэлхийн байгаль хамгаалах сан донор байгууллагуудын дэмжлэгээр ерөнхий боловсролын 40 лаборатори сургуулиудад ТХБ-ын үзэл санааг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж байсан. Түүнчлэн 2008 оноос ШХА-ын “Цөлжилтийг сааруулах” төслийн хүрээнд анх удаа “Эко сургуулийн” хөтөлбөрийг танилцуулан ажиллаж, зорилтот аймгуудын 100 гаруй дунд сургууль хамрагдаж байжээ. Дээрх туршлагуудыг ТХБ төслийн хэрэгжилтэнд хэр зэрэг уялдуулж болох талаар ШХА-с “Олон түвшинт суурь судалгаа” хийсэн байна.<br>Эх сурвалж: https://www.eda.admin.ch/countries/mongolia/mn/ |

9.1. Дараах асуултын дагуу ажиллаарай.

1. АДРА, Швейцарийн хөгжлийн агентлаг олон улсын харилцааны оролцогчийн аль хэлбэрт хамаарах вэ?
2. Улс бус оролцогчийн зорилго, үйл ажиллагаа, үүргийг АДРА, Швейцарийн хөгжлийн агентлагийн жишээн дээр тулгуурлан тодорхойлоорой.

9.2. Иргэн олон улсын харилцааны оролцогч болохыг дээрх жишээн дээр тулгуурлан тайлбарлаарай.

“Токио 2020” Паралимпын нээлтийн үеэр Афганистаны төрийн далбаа гарч ирсэн нь олон улсын сэтгүүлчдийн анхааралыг зүй ёсоор татаж байлаа. Афганистанаас оролцох таэквондогийн Закиа Кодадади, хөнгөн атлетикийн Хоссайн Ласори нар наймдугаар сарын 17-нд Токиод ирэх төлөвлөгөөтэй байсан боловч Исламын шашны Талибан бүлэглэл нийслэл хот Кабулыг эзэлсэн тул нутгаасаа гарч чадахгүй болсон юм. Тийм учраас паралимпын наадмын нээлт дээр НҮБ-ын ажилтан тус улсын тугийг өндөрт өргөж, цэнгэлдэхэд мандуулжээ.Тухайн үед Закиа Кодадади тамирчин Паралимпын хороонд видео мессэж илгээж, “Афганистан улсаас анх удаа эмэгтэй тамирчин оролцох болохоор эрхийг минь бүү хасаарай, та бүхэн дэмжиж туслаарай” хэмээн хүссэн аж.Тэрээр Кабул хотоос нууцаар гарч, Ираны хил хүртэл алхаж, Австралийн тусгай хүчний онгоцоор Франц улсад нэвтэрч, тэндээсээ Японд 8 дугаар сарын 26-ны өдөр иржээ.

Эх сурвалж: https://news.mn/r/2471307/

9.3. Улс ба улс бус оролцогчийн ижил ба ялгааг вен диаграммаар илэрхийлээрэй.



*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:*____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

10. МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалыг судлан дараах заалтуудад тохирох жишээ бичээрэй. Баримт бичиг үзэх холбоос: http://mfa.gov.mn/trade/61577

| Д.д | Гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлогоос | Жишээ |
|---|---|---|
| 1 | Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний хүрээнд хамгаалах | |
| 2 | Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн суугаа болон хавсран суугаа улсад амьдарч, ажиллаж, суралцаж байгаа иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх | |
| 3 | Гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ноцтой гэмт хэрэгт өртөхөөс сэрэмжлүүлэх, ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах чиглэлээр тухайн улсын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах | |
| 4 | Гадаадад байгаа иргэддээ тэдний хууль ёсны эрх, эрх чөлөө, үүрэг, хариуцлагын талаарх шаардлагатай бусад мэдээлэл, зөвлөгөө өгч байх | |
| 5 | Гадаадад буй иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллах | |

10-6. Олон улсын харилцаа

I II III

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:* ____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

11. Монгол, ОХУ-ын болон Монгол, БНХАУ-ын харилцааны тулгуур баримт бичгүүдийг он цагийн дараалаар зөв тэмдэглээрэй. Нийгэм судлал, 2019 оны сурах бичгийн 129-134 дахь талын мэдээллийг ашиглаарай.




11.2. "Мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн хөрш гэж байдаг" гэсэн У.Чирчиллийн хэлсэн үгийн утга санаагаар эргэцүүлэмж бичээрэй.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:*____________ *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

12. Эх сурвалжийг шинжлээрэй

Эх сурвалж 1: 2019 оны есдүгээр сарын 3-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины албан ёсны айлчлалын үеэр “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ”-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар гарын үсэг зурсан.Үүний сацуу ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Дорнод аймгийн Халх гол суманд зохион байгуулж буй Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээнд оролцсон. Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойг хоёр улс өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөсөн ба Игорь Моисеевын нэрэмжит Улсын ардын бүжгийн эрдмийн чуулгын тоглолт, ёслолын жагсаал, буудлага хийх, нисэх хүчний үзүүлэх тоглолт, хоёр орны цэргийн дуучид, бүжигчдийн хамтарсан концерт, хүүхэд залуусын тойрон аяллыг зохион байгуулах зэрэг олон ажлуудыг хийжээ.

Эх сурвалж: https://news.mn/r/2180222/

13. Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээг мэдээллийн эх сурвалжаас сурвалжлан тэмдэглэл хөтлөөрэй.



...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................
...............................................................................................................

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:____________* *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дууссан: Он, сар, өдөр*

14. 1. Мэдээлэлтэй ажиллаарай.

Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт 2016 оны 7 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоотой байж ирээдүйн төлөө түншлэх нь” сэдвийн дор болж өнгөрлөө. Уулзалтад Ази, Европын 51 орны төр, засгийн тэргүүн буюу тэдний өндөр түвшний бие төлөөлөгчид, Европын Зөвлөлийн Ерөнхийлөгч, Европын Комиссын Ерөнхийлөгч, АСЕАН-ы Ерөнхий нарийн бичгийн дарга нар оролцлоо. Дээд түвшний уулзалтыг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж даргалав.
Тэргүүн нар Ази-Европын уулзалтын 20 жилийн ойг тэмдэглэхийн хамт 1996 онд АСЕМ анх байгуулагдснаас хойших ололт амжилтаа дүгнэн цэгнэж, бүс хоорондын эл үйл явцыг ирэх арван жилд хэрхэн бэхжүүлэх, хувьсган хөгжүүлэх талаар баримтлах чиг шугамыг тодорхойлов. АСЕМ-ын ирээдүйг тодорхойлоход хувь нэмэр оруулах үүднээс АСЕМ-ын түншүүдийн гаргаж буй хүч чармайлт, тухайлбал “АСЕМ-ын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох Бангкокын санаачлага”, “Ази-Европын уулзалт-(АСЕМ)-ын ирээдүй: АСЕМ гурав дахь арван жилдээ”, “2025 он хүртэлх Ази-Европын уялдаа холбооны төсөөлөл: сорилт ба боломжууд” зэрэг судалгааны бүтээлүүд, “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбооны сорилт” сэдэвт бага хурлын ач холбогдлыг тэд тэмдэглэв. АСЕМ-ын үйл явцад өгсөн үнэлгээ, ирээдүйн талаарх Тэргүүн нарын төсөөллийг АСЕМ-ын 20 жилийн ойг тохиолдуулан баталж гаргасан “Улаанбаатарын Тунхаглал”-д тусгасан болно. Тэргүүн нар мөн дэлхийн болон өөрсдийн бүс нутгийн улс төр, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар санал бодлоо солилцож, олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн хүрээнд тулгарч буй өнөөгийн болон шинээр гарч ирж буй сорилтуудыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэв.

*Эх сурвалж: https://www.un.int/mongolia/news/Sunday, 17 July 2016. Хурлын даргын мэдэгдэл*

1. Олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд манай улс хэрхэн оролцож байна вэ?
2. АСЕМ-ын 11 дүгээр дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулсан нь Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоонд хэрхэн нөлөөлсөн бэ?

14.2. “АСЕМ-Монголд тоон хэлээр” мэдээлэл бэлтгэн танилцуулаарай.

*Бүлэг сэдэв:*

*Сурагчийн овог, нэр:____________* *Эхэлсэн: Он, сар, өдөр*
*Дуусан: Он, сар, өдөр*

15.Эх сурвалжийг судалсан агуулгатай холбон тайлбарлаарай.

1. 2021 оны 9 дүгээр сарын 24-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцож буй Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Бүгд Найрамдах Серби Улсын Гадаад хэргийн сайд Никола Селаковичтэй Нью-Йорк хотноо уулзаж, “Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Серби Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Энэхүү уулзалт нь Монгол, Сербийн хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн хүрээнд болж байгаагаар онцлог юм.

Эх сурвалж: http://mfa.gov.mn/63811

2. ЗХУ болон фашистын Германы хооронд Москва хотноо 1939 оны 8 дугаар сарын 23-нд байгуулсан харилцан бие бие рүүгээ халдан довтлохгүй үүрэг хүлээсэн "Харилцан үл довтлох тухай" гэрээг Германы Гадаад хэргийн сайд Иоахим фон Риббентроп, ЗХУ-ын Гадаад хэргийн Коммисар Вячеслав Молотов нар хийжээ.Энэхүү гэрээний дагалдах нууц протоколд тухайн хоёр улс европ тивийн хэмжээнд нөлөөллийн хүрээгээ харилцан тохиролцох замаар Балтийн тэнгис орчмын Эстони, Латви, Литва болон Финланд, Польш, баруун Белорусс, Украины нутаг дэвсгэрийг хувааж авахаар тохирсон байлаа.

Эх сурвалж: https:https://mn.wikipedia.org/wiki/

Тайлбар бичих хэсэг

Тайлбар бичих хэсэг

## Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

I II III

| Бүлэг сэдэв/ | Даалгаврын дугаар | Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй. |
|---|---|---|
| **3.Эрх зүй** | 1-5 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **4.Эдийн засаг** | 1-4 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **5. Улс төр** | **1-6** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **6.Олон улсын харилцаа** | **1-5** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |

Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

I II III

| Бүлэг сэдэв/ | Даалгаврын дугаар | Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй. |
|---|---|---|
| **3.Эрх зүй** | 6-13 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **4.Эдийн засаг** | 5-8 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **5. Улс төр** | **7-8** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **6.Олон улсын харилцаа** | **4-7** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |

Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

I II III

| Бүлэг сэдэв/ | Даалгаврын дугаар | Хэрхэн ажилласан, ямар үр дүнд хүрсэн тухай тэмдэглээрэй. |
|---|---|---|
| **3.Эрх зүй** | 14-18 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **4.Эдийн засаг** | 9-11 | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **5. Улс төр** | **9-13** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |
| **6.Олон улсын харилцаа** | **8-15** | |
| Эхэлсэн хугацаа | | |
| Дууссан хугацаа | | |
| Өөрийн үнэлгээ | | |
| Багшийн үнэлгээ | | |